



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 0/227

Улаанбаатар хот

**Хан-Уул дүүргийн Албан бус-Насан  
туршийн боловсролын төвийн эргэлтийн  
хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 7,612,397.0 /долоон сая зургаан зуун арван хоёр мянга гурван зуун ерэн долоо/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв /Г.Рэгзэдмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 4 нэр төрлийн 1,710,938.0 /нэг сая долоон зуун арван мянга есөн зуун гучин найм/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 7 нэр төрлийн 5,901,459.0 /таван сая есөн зуун нэг мянга дөрвөн зуун тавин есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Хан-уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв /Г.Рэгзэдмаа/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ


Ш.ҮНЭНБАТ

D:\Tushaal 2019\Tushaal-1\Тушаал 2019.docx

1118282485 ш.2576589

115050000749

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны 07 сарын  
 09 өдрийн 0/229 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХК Комиссын хурлын шийдвэр
<b>Машин тоног төхөөрөмж</b>										
1	Өнгөт принтер /canon/	20	ш	1	746,755.00	746,755.00	746,755.00	-	эвдэрсэн	татах
2	Приставка	15	ш	1	521,584.00	521,584.00	521,584.00	-	эвдэрсэн	устгах
3	Принтер	10	ш	1	430,200.00	430,200.00	430,200.00	-	эвдэрсэн	татах
4	Өнгөт хэвлэгч	6	ш	1	385,000.00	385,000.00	385,000.00	-	эвдэрсэн	татах
5	Зургийн аппарат	5	ш	1	454,000.00	454,000.00	454,000.00	-	эвдэрсэн	устгах
6	Зөөврийн компьютер	8	ш	1	1,250,000.00	1,250,000.00	1,250,000.00	-	эвдэрсэн	татах
7	Зөөврийн компьютер	5	ш	1	1,485,000.00	1,485,000.00	1,485,000.00	-	эвдэрсэн	татах
8	компьютер	11	ш	1	737,264.00	737,264.00	737,264.00	-	эвдэрсэн	татах
9	Цахим самбар	6	ш	1	867,240.00	867,240.00	867,240.00	-	эвдэрсэн	татах
<b>Машин тоног төхөөрөмжийн дүн</b>						<b>6,877,043.00</b>	<b>6,877,043.00</b>			
<b>Тавилга эд хогшил</b>										
10	Самбар	12	ш	1	73,260.00	73,260.00	73,260.00	-	эвдэрсэн	устгах
11	Номын шкаф	18	ш	3	220,698.00	662,094.00	662,094.00	-	эвдэрсэн	устгах

Тавилга эд хогшилын дүн	4		735,354.00	735,354.00	-		
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн			7,612,397.00	7,612,397.00			
Үүнээс: Худалдах хөрөнгө							
Устгах хөрөнгийн дүн			1,710,938.00				
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн			5,901,459.00				
Худалдсанаас олох орлого							
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/							